

Газар Шим Үйлдвэр ХК

2023 оны 12 сарын 31-нээр  
тасалбар болгосон тайлант жилийн  
Санхүүгийн тайлан болон  
Хараат бус аудиторын тайлан

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН  
2023 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ**

**АГУУЛГА**

Хуудас

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

1

ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

3

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

4

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

5



"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХК  
Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо,  
Үйлдвэрийн баруун бүс, 16102, 66/01, 66/02.  
Шуудангийн хаяг: 37-р салбар, Ш/х-162  
Утас: (976)75059933, 75059999  
И-мэйл: info@gazarshim.mn  
Вэб сайт: www.gazarshim.mn

2024.07.17 № 01/208  
танай \_\_\_\_\_ -ны(ний) \_\_\_\_\_ -т

**Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл**

Цээпэл овогтой Ганбат би Газар шим үйлдвэр ХК (цаашид "Компани" гэх)-ийн гүйцэтгэх захирлын хувьд, Цэцэгээ овогтой Алтанзул би тус компанийн санхүүгийн албаны даргын хувьд ард хавсаргасан 1-ээс 3<sup>р</sup> хуудас дахь Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-нээр санхүүгийн тайлангуудыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 31-нээр санхүүгийн байдал ба уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг шударгаар үзүүлж байна гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



(гарын үсэг)

Ц.ГАНБАТ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

(гарын үсэг)

Ц.АЛТАНЗУЛ

САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Газар Шим Үйлдвэр ХК-ийн Хувьцаа эзэмшигчид танаа,

### Санхүүгийн тайлангийн аудитын тайлан

#### Дүгнэлт

Бид Газар Шим Үйлдвэр ХК (цаашид "Компани" гэх)-ийн 2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, Компанийн 2023 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн зөв, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "НБЁЗОУС3-ын дүрэм" гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба НБЁЗОУС3-ын дүрмийн дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

#### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн үнэлэмжээр Аудитын гол асуудал нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн ач холбогдолтой, нөлөө бүхий асуудал юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудал бүрт тусад нь дүгнэлт гаргаагүй болно. Бид дараах асуудлыг Аудитын гол асуудал гэж тодорхойлсон.

#### Аудитын гол асуудал

##### Орлого хүлээн зөвшөөрөлт

Аудитын Олон Улсын Стандартаар орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой аливаа залилангийн эрсдэл бизнесийн байгууллагад өндөр байдаг гэж үздэг. Тиймээс бид орлого хүлээн зөвшөөрөлтийг энэхүү санхүүгийн тайлангийн аудитын онцлох асуудал гэж авч үзсэн ба удирдлага төлөвлөсөн санхүүгийн үр дүнд хүрэх шахалтийн улмаас бодитоор хийгдээгүй борлуулалтыг бүртгэх эсвэл буруу тайлант жилд борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрөх эрсдлүүд байж болзошгүй гэж тодорхойлсон.

#### Бидний гүйцэтгэсэн аудитын горимууд

Орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:

- Бид удирдлагын зүгээс орлого хүлээн зөвшөөрөхдөө хэрэгжүүлж буй хяналтууд болон бизнесийн процессийн талаар ойлголт олж авсан.
- Борлуулалтын орлого нь зөв тайлант хугацаандаа бүртгэгдсэн эсэх, бүртгэгдсэн борлуулалтын орлого нь бодитоор бий болсон эсэхийг үнэлэхийн тулд түүврийн аргаар борлуулалтын гүйлгээнээс түүвэр сонгож, бараа бүтээгдэхүүнийг харилцагчид хүлээлгэн өгсөн эсэх болон тоо хэмжээ ба үнийн дүн нь зөв эсэхийг холбогдох анхан шатны баримтууд руу тулгасан.
- Мөн түүнчлэн, бид Компанийн борлуулсан бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ болон нэгжийн үнийн мэдээлэлд үндэслэн борлуулалтын орлогыг дахин тооцоолж магадласан.

Onch & Company тухай

Onch & Company нь Монгол Улсын Оюуны өмчийн газарт бүртгэлтэй барааны тэмдэг юм. Энэхүү тэмдэгийг Онч Аудит ХХК, Онч Зөвлөх үйлчилгээ ХХК, Онч Татварын Зөвлөх үйлчилгээ ТМЗ ХХК-иуд ашиглах эрхтэй бөгөөд тэдгээр нь аудит, эрсдэлийн удирдлага, татвар болон хуулийн зөвлөгөө, консалтинг болон санхүүгийн зөвлөгөө зэрэг мэргэжлийн үйлчилгээг Монголын харилцагчдад үзүүлдэг байгууллагууд юм.

© 2024. Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Onch & Company-тай холбогдоно уу.

**Аудитын гол асуудал****Бидний гүйцэтгэсэн аудитын горимууд**

- Бид Компанийн томоохон худалдан авагчид руу тулган баталгаажуулах захидал явуулж, тайлант жилд тухайн харилцагчидтай хийгдсэн борлуулалтын ажил гүйлгээг тулган баталгаажуулсан.
- Тайлант жилийн дараа үед болон тайлант жилийн эцэст хийгдсэн борлуулалтын орлогын болон борлуулалтын буцаалтын гүйлгээнүүд нь бодитой эсэхийг нягталсан.
- Компанийн орлого хүлээн зөвшөөрөх ердийн процессоос гадуур хийгдсэн борлуулалтын орлогын гүйлгээ байсан эсэхийг шалгасан.

**Бусад мэдээлэл**

Компанийн удирдлага нь бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэлд захирлууд ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэлд агуулагдсан мэдээллүүд орох бөгөөд санхүүгийн тайлан болон энэхүү аудиторын дүгнэлт орохгүй. Энэхүү санхүүгийн тайланд өгсөн манай аудиторын дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй бөгөөд бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын ажлын хүрээнд олж мэдсэн мэдээллээс материаллагаар зөрүүтэй эсвэл зөрүүтэй мэт харагдаж байгаа эсэхийг авч үзэх ёстой. Хэрэв бид хийсэн ажил дээрээ үндэслэн бусад мэдээлэл нь материаллаг алдаатай байна гэж үзвэл бодит мэдээллийг тайлагнах үүрэгтэй. Үүнтэй холбоотойгоор ямар нэгэн тайлагнах зүйл байгаагүй болно.

**Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг**

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Удирдлага санхүүгийн тайланг бэлтгэх үедээ Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, уг чадамжид нөлөөлөхүйц нөхцөл байдлын талаар шаардлагатай үед тодруулах болон Компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

**Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг**

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар үл үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг гарган гэрээт ажлын гэрээнд заасан эрх бүхий этгээд болох та бүхэнд хүргүүлэх нь бидний зорилго юм. Энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бид аливаа бусад этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

**Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг (үргэлжлэл)**

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болгож, бид аудитын түршид мэргэжлийн үнэлэмж болон үл итгэх үзлийг баримталсан болно. Мөн түүнчлэн:

- Залилан болон алдаанаас үүсч болохуйц санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлон үнэлж, уг эрсдэлүүдэд тохирох аудитын горимуудыг боловсруулан гүйцэтгэж, аудитын дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай болон зохистой аудитын баримт, нотолгоог олж авна. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс өндөр байдаг. Учир нь залилан нь үгсэн тохирох, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, худал батламж гаргах болон дотоод хяналтыг зөрчих зэрэг явдлуудаас үүссэн байх магадлалтай байдаг.
- Бид Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус зөвхөн нөхцөл байдалд тохирох аудитын горимуудыг сонгох зорилгоор дотоод хяналтуудыг судалдаг.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон удирдлагын бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгуудын зохистой байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн тасралтгүй байх нөхцлийг үргэлжлүүлэн хангах Компанийн чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал болон материаллаг тодорхой бус байдал үүссэн эсэхийг үнэлдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал байгаа гэж үзвэл санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг аудиторын дүгнэлтэнд тусгаж анхааруулах, мөн тэдгээр тодруулгууд нь зохистой биш гэж үзсэн тохиолдолд бид дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай байдаг. Бид дүгнэлтээ аудиторын тайлангийн өдөр хүртэлх олж авсан аудитын нотлох баримтан дээр үндэслэн гаргадаг. Тиймээс ирээдүйд болох үйл явдал эсвэл нөхцөл байдал нь Компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэхэд саад учруулж болох юм.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг бүхэлд нь үнэлдэг ба ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар толилуулсан эсэхийг үнэлдэг.

Аудитор нь засаглах эрх бүхий этгээдтэй зөвхөн аудитын ажлын цар хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад илэрсэн ач холбогдол бүхий асуудлуудын талаар мэдээлдэг ба үүнд аудитын үеэр аудиторын илрүүлсэн дотоод хяналтын томоохон алдаа болон дутагдал орно.

  
Онч Аудит ХХК  
Монгол улс, Улаанбаатар хот  
2024 оны 4-р сарын 17

  
ONCH AUDIT  
LLC  
УЛААНБААТАР ХОТ ШТК0636 922201111 2810743

Б. Анхтайван  
Партнер, МНБ

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН  
2023 ОНЫ 12 САРЫН 31  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Тодруулга	2023	2022
<b>ХӨРӨНГӨ</b>			
<i>Эргэлтийн хөрөнгө</i>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6	20,062,944	1,785,892
Дансны ба бусад авлага	7	3,683,893	6,122,274
Урьдчилгаа төлбөр	8	3,368,857	2,857,480
Бараа материал	9	11,451,680	10,904,852
		<b>38,567,374</b>	<b>21,670,498</b>
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>			
Үндсэн хөрөнгө	10	8,134,587	7,474,665
Биет бус хөрөнгө	11	3,346,318	3,922
Хойшлогдсон татварын хөрөнгө	17.3	1,535	-
		<b>11,482,440</b>	<b>7,478,587</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>50,049,814</b>	<b>29,149,085</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>			
<i>Богино хугацаат өр төлбөр</i>			
Дансны ба бусад өглөг	12	932,714	593,243
Гэрээний өр төлбөр	13	567,058	-
Орлогын татварын өглөг	17.2	791,192	174,750
Банкны зээл	14	1,717,691	692,571
Хойшлогдсон орлого	14.3	785,642	227,429
		<b>4,794,297</b>	<b>1,687,993</b>
<i>Урт хугацаат өр төлбөр</i>			
Банкны зээл	14	5,603,354	1,586,210
Хойшлогдсон орлого	14.3	1,196,646	138,250
Хойшлогдсон татварын өр төлбөр	17.3	-	7,552
		<b>6,800,000</b>	<b>1,732,012</b>
<b>Нийт өр төлбөр</b>		<b>11,594,297</b>	<b>3,420,005</b>
<b>Эзэмшигчдийн өмч</b>			
Хувьцаат капитал	15	131,792	110,000
Нэмж төлөгдсөн капитал	16	9,848,102	-
Эздийн өмчийн бусад хэсэг		-	380,000
Хуримтлагдсан ашиг		28,475,623	25,239,080
		<b>38,455,517</b>	<b>25,729,080</b>
<b>Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>		<b>50,049,814</b>	<b>29,149,085</b>

Холбогдох тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Тодруулга	2023	2022
Борлуулалтын орлого	18.1	34,312,210	30,153,766
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	18.2	(19,779,910)	(20,487,892)
<b>Нийт ашиг</b>		<b>14,532,300</b>	<b>9,665,874</b>
Бусад орлого	19	680,373	412,476
Санхүүгийн зардал	14.2	(596,118)	(726,239)
Ерөнхий ба удирдлагын зардал	20	(5,103,147)	(4,574,848)
Авлагын хүлээгдэж буй алдагдлын сангийн зардал	7.1	(1,712,903)	(50,000)
Бусад олз ба (гарз), цэвэр дүнгээр	21	(50,687)	(53,782)
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>7,749,818</b>	<b>4,673,481</b>
Орлогын албан татварын зардал	17	(1,213,275)	(522,735)
<b>Тайлант жилийн цэвэр ашиг</b>		<b>6,536,543</b>	<b>4,150,746</b>
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг</b>		<b>6,536,543</b>	<b>4,150,746</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр)</b>		<b>5.46</b>	<b>4.15</b>

Холбогдох тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт өмч
<b>2021 оны 12 сарын 31-ний дүн</b>	<b>110,000</b>	-	<b>380,000</b>	<b>21,088,334</b>	<b>21,578,334</b>
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	4,150,746	4,150,746
<b>2022 оны 12 сарын 31-ний дүн</b>	<b>110,000</b>	-	<b>380,000</b>	<b>25,239,080</b>	<b>25,729,080</b>
Хувьцаат капитал шинээр гаргасан (Тодруулга 15.16)	21,792	9,848,102	-	-	9,869,894
Бүсад хөдөлгөөн	-	-	(380,000)	-	(380,000)
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	6,536,543	6,536,543
Зарласан ногдол ашиг (Тодруулга 22.2)	-	-	-	(3,300,000)	(3,300,000)
<b>2023 оны 12 сарын 31-ний дүн</b>	<b>131,792</b>	<b>9,848,102</b>	-	<b>28,475,623</b>	<b>38,455,517</b>

Холбогдох тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК**  
**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
**12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН**  
**(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Тодруулга	2023	2022
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>7,749,818</b>	<b>4,673,481</b>
Тохируулга:			
Элэгдлийн зардал	10	848,605	796,484
Хорогдлын зардал	11	31,324	7,482
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн гарз/(олз)		13,309	(59,708)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	21	24,211	16,766
Бараа материалын хорогдолын зардал	20	80,684	25,923
Авлагын хүлээгдэж буй алдагдлын сангийн зардал	7.1	1,712,903	50,000
Хүүгийн орлого	19	(193,117)	(10,841)
Хүүгийн зардал	14.2	596,118	726,239
Хөнгөлөлттэй зээлийн хорогдуулалтын нөлөө	19	(413,299)	(309,063)
		<b>10,450,556</b>	<b>5,916,763</b>
Дансны ба бусад авлагын бууралт		777,368	2,807,213
Урьдчилгаа төлбөрийн (өсөлт)/бууралт		(511,377)	2,574,943
Бараа материалын өсөлт		(627,512)	(8,202,058)
Дансны ба бусад өглөгийн өсөлт/(бууралт)		339,471	(26,622)
Гэрээний өр төлбөрийн өсөлт		567,058	-
Хойшлогдсон орлогын өсөлт/(бууралт)		1,616,609	(309,063)
		<b>12,612,173</b>	<b>2,761,176</b>
Хүлээн авсан хүү		141,227	10,841
Төлсөн орлогын татвар	17.2	(605,920)	(867,307)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>12,147,480</b>	<b>1,904,710</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн	10	(1,592,336)	(900,797)
Биет бус хөрөнгө худалдан авахад төлсөн	11	(3,373,720)	-
Үндсэн хөрөнгө борлуулснаас орж ирсэн мөнгө		59,598	273,598
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(4,906,458)</b>	<b>(627,199)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Авсан зээл	14.2	5,970,092	2,545,288
Төлсөн зээл	14.2	(927,828)	(2,990,376)
Төлсөн хүү	14.2	(182,819)	(417,176)
Төлсөн ногдол ашиг	22.2	(3,300,000)	(1,050,000)
Хувьцаа нэмж гаргаснаас хүлээн авсан цэвэр мөнгө	15,16	9,869,894	-
Хувьцаа эзэмшигчээс авсан санхүүжилтээс төлсөн		(380,000)	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>11,049,339</b>	<b>(1,912,264)</b>
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл		(13,309)	30,052
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт/(бууралт)</b>		<b>18,277,052</b>	<b>(604,701)</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>1,785,892</b>	<b>2,390,593</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	6	<b>20,062,944</b>	<b>1,785,892</b>

Холбогдох тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**1. Үндсэн үйл ажиллагаа ба зохион байгуулалт**

Газар Шим Үйлдвэр ХК (цаашид "Компани" гэх) нь 1999 онд Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан ба 2023 оны 4-р сард нээлттэй хувьцаат компани болж Монголын Хөрөнгийн Биржид бүртгэгдсэн. 2023 оны 12 сарын 31-ны байдлаар хувьцаа эзэмшигчид дараах байдалтай байна:

- 42.57%-ийг Ц.Ганбат
- 12.52%-ийг Стеффен Мелзер
- 10.85%-ийг Ц.Төгсөө
- 9.18%-ийг З.Байгалмаа
- 4.17%-ийг Д.Сэргэлэн
- 4.17%-ийг Г.Түвшинзаяа
- 16.54%-ийг бусад хувьцаа эзэмшигчид

2023 болон 2022 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилд Компани нь Монгол улсад хүнсний ногоо савлах худалдаалах, даршилсан ногоо, жимс жимсгэнэ бүхий хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хүнсний бөөний болон жижиглэн худалдаа, жимс жимсгэнэ, хүнсний ногоо тариалах худалдах, ундаа жүүс үйлдвэрлэх үндсэн үйл ажиллагаа явуулсан.

Компанийн албан ёсны хаяг нь нь Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, 66/2 болно.

Энэхүү санхүүгийн тайланг гүйцэтгэх удирдлага 2024 оны 4 сарын 17-ны өдөр батлан гаргасан.

**2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй**

**2.1 Мөрдсөн стандарт**

Компани нь санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-с гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэж, тайлагнасан болно.

**2.2 Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь**

Санхүүгийн тайланг түүхэн өртөгт үндэслэн бэлтгэсэн. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцох үеийн бодит үнэ цэнэ байдаг.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Компанийн үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлсэн. Бүх санхүүгийн мэдээллийг өөрөөр заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлсэн болно.

**2.3 Бараа материал**

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнадаг. Бараа материалын өртгийг сарын жигнэсэн дундаж өртгийн аргаар тооцоолдог. Цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь хэвийн бизнесийн нөхцөлд бараа материалын тооцоолсон худалдан борлуулах үнээс түүнийг үйлдвэрлэх болон худалдан борлуулахад нэмж гарахаар тооцсон зардлыг хассан дүн юм.

**2.4 Урьдчилж төлсөн тооцоо ба урьдчилгаа**

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь гарч амжаагүй төлбөр эсвэл бараа материалаа хүлээн аваагүй төлбөрөөс бүрдэнэ. Урьдчилгаа төлбөрийг анх хөрөнгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд ашиг, алдагдлаар, бараа болон үйлчилгээг хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгө рүү ангилдаг.

Урьдчилгаатай холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагдах бол урьдчилгааг санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд урьдчилгааг эргэлтийн бус хөрөнгөөр ангилна.

Тайлант жилийн эцэст Компани урьдчилгаа төлбөрийн дансны үнэд үнийн цэнийн бууралт гарсан эсэхийг хянадаг.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.5 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгө нь хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын дүнг хассан өртгөөр тайлагнагдана.

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг дараах зардлуудаас бүрдэнэ. Үүнд:

- Хөнгөлөлт урамшууллын дараах худалдан авсан үнэ, гаалийн татвар болон худалдан авалттай холбоотой буцаан олгогдохгүй татвар; болон
- Үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцөлийг хангахтай холбоотой гарсан аливаа шууд зардлууд

Зардалд мэргэжлийн үр чадварын хөлс, шаардлага хангасан хөрөнгийн хувьд компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу капиталжуулсан зээлийн зардлыг багтаасан болно. Эдгээр шинж чанаруудыг ашиглалтад оруулахад бэлэн болсны дараа эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн зохих ангилалд ангилдаг.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан дараа үеийн зардал нь тухайн хөрөнгийн анх тооцсон бүтээмжийн түвшинг нэмэгдүүлэх замаар Компанид эдийн засгийн ирээдүйн өгөөжийг авчрах магадлалтай үед зардлын дүнгээр хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлдэг.

Бусад бүх худалдан авалтын дараа гарсан зардлуудыг гарсан тайлант үед нь зардлаар бүртгэнэ. Эдгээр хөрөнгө нь бусад үндсэн хөрөнгөтэй ижил сууриар ашиглагдаж эхэлсэн үеэсээ элэгдэж эхэлнэ.

Худалдаж авсан программ хангамж нь холбогдох тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой бол тухайн тоног төхөөрөмжийн нэг хэсэг байдлаар капиталжуулна.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг үндсэн хөрөнгийн өртгөөс тэдгээрийн үлдэх өртгийг хассан дүнгээс шулуун шугамын аргаар, дараах тооцоолсон элэгдлийн жилээр тооцоолно. Үүнд:

Барилга байгууламж	25 жил
Машин тоног төхөөрөмж	10-25 жил
Тавилга, эд хогшил	2-10 жил
Компьютер дагалдах хэрэгсэл	1-5 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Бусад үндсэн хөрөнгө	1-10 жил

Газрыг элэгдүүлдэггүй.

Тооцоолсон ашиглалтын жил, үлдэх өртөг болон элэгдэл бодох аргыг тайлан гаргах үе бүрд хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Үйлдвэрлэл, ханган нийлүүлэлт, захиргааны эсвэл хараахан тодорхойлогдоогүй зориулалтаар баригдаж буй үл хөдлөх хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын дүнг хассан өртгөөр тайлагнана. Өртөг нь мэргэжлийн үйлчилгээний хөлс ба шалгуур хангасан хөрөнгийн хувьд компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу капиталжуулсан зээлийн өртөг багтаана. Эдгээр хөрөнгийн элэгдлийн тооцоо нь бусад эд хөрөнгийн адил тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад бэлэн болсон үед эхэлдэг.

Үндсэн хөрөнгийг зарж борлуулах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл үндсэн хөрөнгийг бүртгэлээс хасдаг. Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд тусгана.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.6 Биет бус хөрөнгө**

Ашиглагдах жил нь тодорхой, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжсэн. Биет бус хөрөнгийн хорогдлыг шулуун шугамын аргаар, биет бус хөрөнгийн ашиглалтын жилээр тооцоолсон. Тооцоолсон ашиглалтын жил болон элэгдэл бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг. Ашиглагдах жил нь тодорхойгүй, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжсэн.

Биет бус хөрөнгийн ашиглалтын жил нь 1-ээс 3 жил.

Биет бус хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл хөрөнгийн зүйлийг бүртгэлээс хасдаг. Биет бус хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд тусгана.

**2.7 Биет ба биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

Тайлант үеийн эцэст Компани биет хөрөнгүүдийн дансны үнэд үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илэрсэн эсэхийг шалгадаг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол үнэ цэнэ бууралтын алдагдлыг (ийм алдагдал гарсан бол) тогтоохын тулд тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно. Хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тухайн хөрөнгийн хувьд тооцоолох боломжгүй бол уг хөрөнгийн харьяалагдах "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн нөхөгдөх боломжтой үнийг тооцоолно. "Мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хуваарилах боломжийн бөгөөд тууштай суурь үзүүлэлтийг тодорхойлж чадвал аж ахуйн зориулалттай хөрөнгийг тодорхой "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хуваарилах ба ийм боломжгүй бол хамгийн боломжийн бөгөөд тууштай ашиглах боломжтой суурь үзүүлэлтийг ашиглан хамгийн жижиг "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-д хамааруулан хуваарилна.

Хөрөнгийн эсвэл "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн нөхөгдөх боломжтой үнэ гэдэг нь хөрөнгийн бодит үнээс борлуулах өртөг зардлыг хассан цэвэр дүн ба хөрөнгийг ашигласнаар олж болох өгөөж хоёрын аль ихээр нь тогтоогдоно. Ашигласнаар олж болох өгөөжийг үнэлэхдээ татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтлан тооцсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг ашигладаг. Дискаунтын хувь нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдлийн одоогийн зах зээлийн үнэлэмжийг тусгасан байх ёстой. Үнэ цэнэ бууралтын шалгалтын зорилгоор дангаар нь шалгах боломжгүй хөрөнгийг цаашид ашигласнаар бусад хөрөнгө эсвэл бүлэг хөрөнгөөс ("мөнгөн орлого үүсгэгч нэгж") хамааралгүйгээр дангаараа мөнгөн орлого бий болгох чадвартай хамгийн жижиг хөрөнгийн бүлэгт хамааруулан шалгадаг.

Нэгж хөрөнгө эсвэл түүний харьяалагдах "мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн дансны үнэ нь нөхөгдөх боломжтой тооцоолсон үнээс их байвал үнэ цэнэ бууралтын алдагдлыг бүртгэж дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. "Мөнгөн орлого үүсгэгч нэгж"-ийн хувьд тодорхойлсон үнэ цэнэ бууралтын алдагдлыг бүртгэхдээ эхлээд тухайн нэгжид хуваарилагдсан гүүдвильийн дансны үнийг бууруулах ба үлдсэн алдагдлын дүнгээр тухайн нэгж (бүлэг нэгж)-д багтсан бусад хөрөнгийн дансны үнийг хувь тэнцүүлэн бууруулна.

Өмнөх жилүүдэд бүртгэсэн үнэ цэнэ бууралтын алдагдал буурсан эсвэл алдагдал үгүй болсон эсэхийг илрүүлэхийн тулд үнэ цэнэ бууралтын алдагдлыг тайлангийн өдрөөр дахин хянана. Нөхөгдөх боломжтой дүнг тодорхойлоход хэрэглэсэн тооцоолол өөрчлөгдсөн бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана. Үнэ цэнийн бууралт бүртгээгүй байсан бол байх байсан элэгдэл хорогдлыг хассан хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй байхаар бодож үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.8 Санхүүгийн хэрэгслүүд**

Компани тухайн хэрэгслийн гэрээний нэг оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өрийг санхүүгийн байдлын тайланд тусгадаг.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх үүсэх үеийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Санхүүгийн хэрэгсэл (бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслээс бусад)-ийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг анх бүртгэлд тусгахдаа санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дээр нэмж эсвэл ба өр төлбөрийн бодит үнэ цэнээс хасаж бүртгэнэ. Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг шууд тухайн жилийн ашиг алдагдлаар бүртгэнэ.

**2.9 Санхүүгийн хөрөнгө**

Ердийн журмаар худалдах, худалдан авах санхүүгийн хөрөнгийг бодит гүйлгээ гарсан өдрөөр нягтлан бодох бүртгэлд тусгах эсвэл бүртгэлээс хасдаг. Ердийн журмаар худалдах худалдан авах гэдэг нь тогтоосон хугацааны дотор эсвэл тухайн зах зээл дээр тогтсон дүрэм журмаар хөрөнгийг шилжүүлэх нөхцлөөр санхүүгийн хөрөнгийг худалдах, худалдан авахыг хэлнэ.

Санхүүгийн хөрөнгийг ангиллаас нь хамааран санхүүгийн хөрөнгийг анх бүртгэсний дараа хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнээр нь хэмждэг.

**2.9.1 Санхүүгийн хөрөнгийн ангилал**

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэгслүүд нь дараа үеүдэд хорогдуулсан өртгөөр хэмжигдэнэ:

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой бизнесийн загвараар эзэмшдэг
- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцлөөр тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэгслүүдийг хэмжихдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн бусад дэлгэрэнгүй орлогоор тусгана. (БҮЦБИБО):

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд эсвэл арилжаалах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилго бүхий бизнесийн загвараар эзэмшдэг
- Тодорхойлон заасан өдрүүдэд зөвхөн төлөгдөөгүй үлдсэн үндсэн төлбөр ба хүү төлөлтийн мөнгөн урсгалыг хүлээн авах санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлтэй байх.

Бусад санхүүгийн хөрөнгийг хэмжихдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг (БҮЦАА).

Дээр дурдсанаас үл хамааран, Компани санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед дараах ангиллыг сонгон бүртгэж болно:

- Компани тодорхой шалгууруудыг хангасан тохиолдолд буцаах сонголтгүйгээр өмчийн хэрэглүүр дэх хөрөнгө оруулалтыг дараа үеүдэд хэмжихдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор тусгана.
- Компани өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртөг эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэх зарчмыг сонгосон байсан боловч бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тайлагнах нь илүү тохиромжтой, бүртгэлийн нийцгүй байдлыг арилгана гэж үзэж байвал бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн жилийн ашиг алдагдлыг тусгаж болно.

Компанийн санхүүгийн хөрөнгө нь хорогдуулсан өртгөөр бүртгэдэг санхүүгийн хөрөнгөөс бүрдэж байна.

## **2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

### **2.9.1 Санхүүгийн хөрөнгийн ангилал (үргэлжлэл)**

*Хорогдуулсан өртөг болон үр ашигт хүүгийн арга*

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өрийн хорогдуулсан өртгийг тооцоолон, хүүгийн орлогыг хугацааны туршид хуваарилах арга юм.

Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгөөс бусад (анхлан хүлээн зөвшөөрөхдөө үнэ цэнэ нь буурсан хөрөнгө) санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр (үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан)-ийг санхүүгийн өрийн гэрээний хугацааны эцэс гэхэд анх бүртгэсэн цэвэр дансны үнэтэй тэнцүү байхаар үнэ цэнийн бууралтын нөөцийг хасахын өмнөх төлбөрийг өрийн хугацаа эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хуваарилахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгийн хувьд гэрээний мөнгөн урсгалыг тооцоолох үед ирээдүйн нийт хугацаанд хүлээгдэж буй авлага ба зээлийн алдагдлыг оруулан тохируулсан үр ашигт хүүгийн түвшинг ашиглан өрийн хэрэглүүрийг анхлан хорогдуулан бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн дүнгээс үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж, анхны дүн ба дуусгавар болох үеийн дүнгийн хооронд үүссэн аливаа зөрүүг үр ашигт хүүний арга ашиглан тооцсон хорогдуулгыг нэмж аливаа алдагдлын нөөцийг тохируулсан дүнгээр тодорхойлогдоно. Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь аливаа алдагдлын нөөцөөр тохируулаагүй дүн байна.

Хүүгийн орлогыг бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь дараа үеүдэд тухайн жилийн бусад дэлгэрэнгүй орлогоор тусгах эсвэл хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэрэгслийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан бүртгэлд тусгадаг.

Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгийн хувьд, дараа үед үнэ цэнэ буурсан зээл ба авлагаас бусад, санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүний түвшинг ашиглан авлага ба зээлийн дансны дүнгээс хүүгийн орлогыг тооцно. Санхүүгийн хөрөнгийн анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээл ба авлагын үнэ цэнийн бууралт бий болсон санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүний түвшинг ашиглан аливаа алдагдлын нөөцийг багтаасан цэвэр дансны дүнгээс хүүний орлогыг тооцно.

Хэрэв дараагийн тайлагналын үеүдэд, үнэ цэнэ буурсан зээл ба авлагын санхүүгийн хэрэгслийн эрсдэл буурч, үнэ цэнийн бууралтгүй болох үед үр ашигт хүүгийн түвшинг ашиглан санхүүгийн хөрөнгийн дансны дүнгээс хүүгийн орлогыг тооцно.

Хүүгийн орлогыг тайлант үеийн ашиг, алдагдлаар тайлагнадаг ба "санхүүгийн болон бусад орлого - хүүгийн орлого" хэсэгт ангилна.

### **2.9.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

Компани хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн өмчийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтанд хүлээгдэж буй алдагдлыг хүлээн зөвшөөрөн бүртгэдэг. Тухайн санхүүгийн хэрэгслийг хүлээгдэж буй алдагдлын дүн анх хүлээн зөвшөөрч бүртгэснээс хойш эрсдэлийн өөрчлөлтийг үнэлж тайлант хугацаа болгонд шинэчилнэ.

Компани дансны авлагад нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдлыг тооцоолон бүртгэдэг. Зөвхөн нэг харилцагчтай тул Компани дансны авлагыг тусгайлсан үнэлгээ хийж үнэлдэг.

Нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдал нь санхүүгийн хэрэгслийн хүлээгдэж буй нийт хугацааны туршид гарах бүхий л боломжит дефолт үйл явдлаас үүсэх алдагдлыг илэрхийлнэ.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.9.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

*(i) Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт*

Санхүүгийн хэрэгслийн зээлийн эрсдэл нь анх бүртгэлд тусгаснаас хойш мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг үнэлэхдээ Компани анх бүртгэлд тусгасан өдрийн санхүүгийн хэрэгслээс үүссэн эрсдлийг, тайлант өдрөөрх эрсдлийн дүнтэй харьцуулдаг. Энэхүү үнэлгээг хийхдээ Компани үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц тоон болон чанарын мэдээллийн аль алиныг нь харгалзан үзэх ба эдгээр нь түүхэн туршлага болон өндөр хүчин чармайлт, өртөг шаардахааргүйгээр олж авах боломжтой ирээдүйг таамаглаж буй мэдээллүүд байна. Ирээдүйг таамаглаж буй мэдээлэл нь Компанийн зээлдэгчийн үйл ажиллагаа эрхэлдэг салбарын ирээдүйн хэтийн төлвийг агуулсан, эдийн засгийн шинжээчийн тайлангаас авсан мэдээлэл болон санхүүгийн шинжээч, засгийн газрын байгууллага, холбогдох судалгааны байгууллага, бусад ижил төстэй байгууллагаас гаргасан мэдээллүүд болон Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой эдийн засгийн бодит болон урьдчилан таамагласан янз бүрийн гадаад эх сурвалжийн мэдээллүүдийг авч үздэг.

Зээлийн эрсдэл нь анх хүлээн зөвшөөрснөөс хойш мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг үнэлэхдээ дараах мэдээллийг харгалзан үзнэ:

- Санхүүгийн хэрэгслийн гадаад (хэрэв байгаа бол) эсвэл дотоод зээлийн үнэлгээний бодит эсвэл хүлээгдэж буй мэдэгдэхүйц бууралт;
- Тухайн санхүүгийн хэрэгслийн гадаад зах зээлийн эрсдлийн үзүүлэлтүүдийн бууралт. Үүнд: ижил төстэй хэрэглүүрийн өгөөжийн түвшин ихээхэн ялгаатай байх, зээлийн эрсдлийг солилцох гэрээний үнэ эсвэл шаардагдах цаг хугацаа болон үргэлжлэх байдлын улмаас санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь хорогдуулсан өртгөөсөө бага байх зэрэг юм;
- Одоо байгаа эсвэл урьдчилан таамагласан бизнест нөлөөлж болохуйц сөрөг өөрчлөлт, зээлдэгчийн өрийг эргэн төлөх чадварыг бууруулж болзошгүй нөлөөлөх санхүүгийн эсвэл эдийн засгийн нөхцөл байдлууд;
- Зээлдэгчийн үйл ажиллагааны бодит эсвэл хүлээгдэж буй үр дүнгийн мэдэгдэхүйц бууралт;
- Зээлдэгчийн бусад санхүүгийн хэрэгслүүдийн зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц өсөлт;
- Зээлдэгчийн хууль эрх зүй, эдийн засаг, технологийн орчинд гарч буй бодит буюу хүлээгдэж буй томоохон сөрөг өөрчлөлтүүд нь төлбөрийн үүргээ биелүүлэх чадварыг мэдэгдэхүйцээр бууруулах

Дээрх үнэлгээний үр дүнгээс үл хамааран Компани анх бүртгэлд тусгаснаас хойш гэрээний төлбөр 30 хоногоос дээш хугацаагаар хэтэрсэн үед санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн гэж үзнэ. Хэрвээ зээлийн эрсдэл мэдэгдэхүйцээр нэмэгдээгүйг илтгэх үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц нотолгоо байгаа тохиолдолд эрсдлийг мэдэгдэхүйцээр нэмэгдсэн гэж үзэхгүй байж болно.

Хэрэв санхүүгийн хэрэгсэл нь тайлант өдрөөр эрсдлийн түвшин бага гэж тодорхойлогдсон бол дээр дурдсанаас үл хамааран Компани санхүүгийн хэрэгслийн зээлийн эрсдэл анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц өсөлт гараагүй гэж үздэг. Санхүүгийн хэрэгсэл нь дараах нөхцөлд зээл ба авлагын эрсдэл бага гэж тодорхойлогдоно.

- Санхүүгийн хэрэгсэл нь эргэн төлөгдөхгүй байх эрсдэл багатай,
- Зээлдэгч ойрын хугацаанд гэрээний мөнгөн урсгалын үүргийг биелүүлэх бүрэн чадавхитай,
- Урт хугацаанд эдийн засгийн болон бизнесийн нөхцөл байдалд гарах сөрөг өөрчлөлт нь зээлдэгч гэрээний мөнгөн урсгалын үүргээ биелүүлэх чадварыг бууруулж болзошгүй боловч энэ нь заавал бууруулна гэж тооцохгүй байж болно.

Хэрэв Компанийн хөрөнгө нь дэлхийн түвшинд танигдсан зээлийн үнэлгээний тодорхойлолттой нийцсэн эсвэл хөндлөнгийн үнэлгээний мэдээллийн олдоц хомс тохиолдолд, дотооддоо хэвийн гэж үнэлсэн санхүүгийн хөрөнгийг эрсдэл багатай гэж үзнэ. Хэвийн гэсэн үнэлгээ нь оролцогч тал санхүүгийн хувьд өндөр чадавхтай бөгөөд өнгөрсөн хугацаанд хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй үүрэг үүсээгүй байхыг хэлнэ.

Компани зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг тодорхойлоход ашигласан шалгуурууд нь зээлийн төлөгдөх хугацаа хэтрэхээс өмнө эрсдлийн мэдэгдэхүйц өсөлтийг тодорхойлох үр ашигтай үзүүлэлтүүд гэдгийг тогтмол хянадаг ба шаардлагатай тохиолдолд өөрчилдөг.



**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.9.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

*(ii) Дефаултын тодорхойлолт*

Компани дотоод удирдлагын зорилгоор түүхэн түршлагад үндэслэн зээлийн эрсдлийн дараах шалгууруудын аль нэгийг нь хангасан санхүүгийн хөрөнгүүд нь нөхөгдөх боломжгүй болсон үед үүнийг дефаулт үйл явдал гэж үздэг:

- Зээлдэгч гэрээнд заасан санхүүгийн харьцаа үзүүлэлтүүдийг зөрчсөн тохиолдолд; эсвэл
- Зээлдэгчийн талаар дотооддоо боловсруулсан эсвэл гадаад эх сурвалжаас авсан мэдээлэл нь зээлдэгч бусад зээлдүүлэгчдэд болон Компанид зээл ба авлагаа бүрэн эргүүлэн төлөх магадлал багатайг илэрхийлж буй тохиолдолд (Компанийн эзэмшиж буй барьцаа хөрөнгийг харгалзан үзэхгүй).

Дээрх шалгуураас үл хамааран Компанийн санхүүгийн хөрөнгийн төлбөр төлөх хугацаа 90 хоноогоос дээш хугацаагаар хэтэрсэн бол дефаулт үйл явдал гэж үзнэ. Хэрвээ гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд нэмэлт хугацаа хэрэгтэй болсныг батлах үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц мэдээлэл байгаа бол дээрх тодорхойлолтонд хамаарахгүй байж болно.

*(iii) Зээлийн үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгүүд*

Нэг болон түүнээс дээш үйл явдал тухайн санхүүгийн хөрөнгөөс хүлээн авахаар тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тохиолдолд тухайн санхүүгийн хөрөнгө нь зээлийн үнэ цэнийн бууралттай гэж үзнэ. Дараах тодорхойлолтууд нь санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэ цэнэ буурсан илэрхий нотолгоо болох юм:

- Үнэт цаас гаргагч эсвэл зээлдэгч талд томоохон хэмжээний санхүүгийн хүндрэл үүссэн;
- Гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, тухайлбал эргэн төлөлтийг төлбөрийн хугацааг хэтрүүлэх эсвэл төлөх чадамжгүй болох (дээр дурдсан (ii)- ийг харна уу);
- Зээлдэгчийн санхүүжүүлэгч нь зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй байдлаас үүссэн эдийн засгийн болон гэрээний шалтгааны улмаас зээлдэгчидтэй тохирсон үүрэг амлалтаа хэрэгжүүлэх боломжгүй болох;
- Зээлдэгч нь дампуурлаа зарлах эсвэл санхүүгийн хувьд дахин бүтцийн өөрчлөлт хийх магадлалтай болсон; эсвэл
- Санхүүгийн хүндрэлээс болж тухайн санхүүгийн хөрөнгийн идэвхтэй зах зээл байхгүй болох.

*(iv) Бүртгэлээс хасах*

Компани санхүүгийн хөрөнгийг зээлдэгч нь томоохон санхүүгийн хүндрэлд орсон ба зээлдэгчийн татан буугдах эсвэл дампуурах үйл явц эхэлсэн, авлага төлөгдөх хугацаа 2 жилээс дээш хугацаагаар хэтэрсэн зэрэг үйл явдлын аль нэг нь бий болсон үед буюу авлагын эргэн төлөлт хийгдэх бодит боломж байхгүй болсон үед бүртгэлээс хасна. Бүртгэлээс хасагдсан санхүүгийн хөрөнгийг Компанийн бодлогын дагуу авлага цуглуулах үйл явц хийгдэж, хуулийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч болно. Бүртгэлээс хасагдсан авлага нь эргэн төлөгдсөн тохиолдолд тайлант жилийн ашиг, алдагдлын тайланд тусгана.

*(v) Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилт ба бүртгэл*

Хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдал нь төлбөр төлөгдөхгүй байх магадлал, алдагдал үүсэх магадлал болон эрсдэлд өртөх боломжтой зээл ба авлагын дүнгийн үржвэр юм. Төлбөр төлөгдөхгүй байх магадлал болон алдагдал үүсэх магадлалын үнэлгээ нь ирээдүйг таамаглаж буй мэдээллээр залруулагдсан түүхэн мэдээлэлд үндэслэгддэг.

Тайлагналын өдрийн байдлаар дансны үнээрээ толилуулагдсан эрсдэлтэй зээлийн санхүүгийн хөрөнгийг Компанийн зээлдэгчийн ирээдүйд шаардагдах санхүүжилтийн хэмжээ болон ирээдүйг таамаглаж буй мэдээлэлүүд ашиглан тодорхойлно.

Санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй зээлийн алдагдал нь гэрээний дагуу Компанийн хүлээн авах эрх бүхий нийт мөнгөн урсгал болон Компанийн хүлээн авахаар тооцоолсон бүх мөнгөн гүйлгээг үр ашигт хүүгийн аргаар дискаунтчилсан дүнгийн зөрүүгээр тооцоологддог.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.9.2 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

Хэрэв өмнөх тайлант үед санхүүгийн хэрэгслийн алдагдлын нөөц сан нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлаар хэмжигдсэн хэдий ч тайлант жилийн эцэст нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлын шалгуурыг хангаагүй бол Компани хялбарчилсан аргачлал ашигласан хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгийн хувьд тайлант жилийн эцсээрх 12 сарын хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлыг тооцоолдог.

Компани бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн бусад дэлгэрэнгүй орлогоор хэмждэг өрийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтаас бусад бүх санхүүгийн хэрэгслийн үнэ цэнийн бууралтын алдагдал болон буцаалтыг үнэ цэнийн бууралтын нөөц сангийн дансаар дамжуулан тэдгээрийн дансны үнийг залруулж, ашиг алдагдлаар бүртгэнэ.

**2.9.3 Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах**

Компани нь санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд данснаас хасна: санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон эсвэл санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх ба хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг бусдад шилжүүлсэн. Хэрэв Компани нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлээгүй боловч санхүүгийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг хадгалж үлдээгүй бол уг хөрөнгөөс Компанид үлдсэн хувь хэмжээгээр хөрөнгийг бүртгэлдээ хэвээр үлдээх ба төлбөр төлөх үүрэг байгаа бол холбогдох өрийг бүртгэнэ. Хэрэв Компани нь шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийн ихэнхийг өөртөө хадгалсаар байгаа бол санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасахгүй ба санхүүгийн хөрөнгөөр барьцаалсан зээлийн өрийг бүртгэнэ.

Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийг данснаас хасахдаа тухайн хөрөнгийн дансны үнэ ба хүлээн авсан дүн болон авлагын нийлбэрийн зөрүүг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

**2.10 Санхүүгийн өр төлбөр ба өмчийн хэрэгсэл**

**2.10.1 Өр эсвэл өмчийн хэрэгслээр ангилах**

Компаниас гаргаж байгаа өрийн болон өмчийн хэрэгслийг тэдгээрийн гэрээнд тусгагдсанаар ямар нөхцөл, бодит байдал үүссэн бөгөөд санхүүгийн өр эсвэл өмчийн хэрэгслийн тодорхойлолтод нийцэж байгаа эсэхийг үндэслэн өр эсвэл өмчийн хэрэгсэл гэж ангилдаг.

**2.10.2 Өмчийн хэрэгсэл**

Компанийн бүх хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгээс хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэдэг. Компаниас гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжиж бүртгэдэг.

**2.10.3 Санхүүгийн өр төлбөр**

Бүх санхүүгийн өр төлбөрийг анх бүртгэсний дараа үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Компанийн санхүүгийн өр төлбөр нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хэрэгслүүдээс бүрддэг.

**2.10.3.1 Хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн санхүүгийн өр төлбөр**

Санхүүгийн өрийг бодит хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр хэмжиж бүртгэнэ. Бодит хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өрийн хорогдуулсан өртгийг бодох ба хүү тооцох хугацааны турш бүртгэх хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Бодит хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр (бодит хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан)-ийг санхүүгийн өрийн гэрээний хугацааны эцэс гэхэд анх бүртгэсэн цэвэр дансны үнэтэй яг тэнцүү байхаар төлбөрийг өрийн хугацаа эсвэл (шаардлагатай тохиолдолд) түүнээс богино хугацаанд хуваарилахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.10 Санхүүгийн өр төлбөр ба өмчийн хэрэгсэл (үргэлжлэл)**

2.10.3.2 Санхүүгийн өрийг бүртгэлээс хасах

Компани нь санхүүгийн өрийг зөвхөн гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд бүртгэлээс хасна. Бүртгэлээс хасч буй санхүүгийн өрийн дансны үнэ ба түүний оронд хүлээн авсан ба авах хэрэгслийн хооронд үнийн зөрүү гарвал уг зөрүүг ашиг алдагдлаар бүртгэнэ.

**2.11 Орлого хүлээн зөвшөөрөлт**

Гүйцэтгэлийн үүргээ биелүүлсэн эсвэл тодорхой гүйцэтгэлийн үүргийн үндсэн дээр байгаа бараа, үйлчилгээний "хяналт" нь үйлчлүүлэгчид шилжсэн үед компани орлогыг хүлээн зөвшөөрдөг.

Гүйцэтгэлийн үүрэг гэдэг нь өөр хоорондоо ялгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх үүргийг хэлнэ.

Дараах шалгууруудын аль нэг нь хангагдсан тохиолдолд Компани холбогдох гүйцэтгэлийн үүргийг тодорхой хугацааны туршид биелэгдэх гүйцэтгэлийн үүрэг гэж үзэж тэрхүү хугацааны туршид орлогоо хэсэгчлэн хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Компани гүйцэтгэлийн үүргээ биелүүлсэн цаг хугацаатай зэрэгцэн, уг ажлын гүйцэтгэлээр дамжуулан худалдан авагч үр өгөөж хүртэх;
- Компанийн гүйцэтгэлийн үүргийн биелэлт нь ямар нэг хөрөнгийг бий болгодог эсвэл хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлдэг бөгөөд уг хөрөнгө бий болсон эсвэл үнэ цэнэ нь нэмэгдэх бүрт худалдан авагч хяналтыг өөртөө авах;
- Компанийн гүйцэтгэлийн үүргийн биелэлтээр дамжин бий болж буй хөрөнгийг Компани ашиглаж үр өгөөж хүртэх боломжгүй хэдий ч гүйцэтгэлийн үүрэг хангагдах бүрт төлбөр хүлээн авах эрхтэй байх.

Бусад тохиолдолд, худалдан авагч нь өөр хоорондоо ялгаатай бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний хяналтыг авах үед тодорхой нэг хугацаанд хангагдах гүйцэтгэлийн үүрэг гэж үзэж орлогыг хүлээн зөвшөөрнө.

Компанийн орлого нь салат, өргөст хэмх, компот, нухаш, хөлдөөсөн ногоо, ундаа болон зөгийн бал, артишокийн борлуулалтын орлогоос бүрддэг бөгөөд бараа, бүтээгдэхүүний хяналтыг худалдан авагч талд шилжүүлсэн буюу гүйцэтгэлийн үүрэг хангагдсан тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө.

**2.12 Гадаад валют**

Төгрөгөөс бусад мөнгөн тэмдэгт нь гадаад валют гэж тооцогддог ба гадаад валютаар хийгдсэн гүйлгээнүүд нь тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэгддэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөр нь тухайн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэгддэг. Энэхүү гадаад валютын хөрвүүлгийн гүйлгээнээс үүссэн ханшийн зөрүүг тухайн тайлант хугацаанд дэлгэрэнгүй орлогын тайлангийн хэсэгт тусгадаг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн хөрөнгө ба өр төлбөр нь түүхэн ханшаараа хэмжигдэх бөгөөд дахин хөрвүүлэлт хийдэггүй.

**2.13 Зардал хүлээн зөвшөөрөлт**

Зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд зардлын чиг үүргийн аргыг ашиглан тайлагнадаг. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт борлуулсан барааны бүтээгдэхүүнтэй шууд холбоотой зардлууд багтдаг. Харин үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын, борлуулалт, маркетингийн болон Компанийн бусад бизнесийн үйл ажиллагааны зардлууд ордог.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.14 Сегментийн мэдээлэл**

Үйл ажиллагааны сегмент гэдэг нь аж ахуйн нэгжийн дараах шинж чанаруудыг агуулсан бүрэлдэхүүн юм:

- Орлого олж, зардал гаргадаг (аж ахуйн нэгжийн доторх бусад бүрэлдэхүүн хэсгүүдтэй хийсэн орлого, зардлын ажил гүйлгээ мөн багтана) бизнесийн үйл ажиллагаа;
- Сегментэд нөөц хуваарилах, гүйцэтгэлийг үнэлэхтэй холбоотой шийдвэр гаргах зорилгоор аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны шийдвэр гаргагч ахлах ажилтны зүгээс үйл ажиллагааны үр дүнг нь тогтмол хянаж байдаг;
- Санхүүгийн мэдээлэл бэлтгэх боломжтой.

Дээрх шаардлагыг хангасан сегментүүдийн хувьд уг Компани сегмент бүрээр ашиг, алдагдал, хөрөнгө, өр төлбөрийг тодруулах шаардлагатай.

Компани нь борлуулалтын сувгаар жижиглэн худалдааны харилцагчид, зах болон бөөний төвүүд, сүлжээ дэлгүүрүүд, хөдөө орон нутгийн гэрээт борлуулагч, нэрийн дэлгүүр, агуулах болон үзэсгэлэн гэсэн сегментүүдтэй ба эдгээр сегмент тус бүрээр борлуулалтын орлого болон борлуулалтын өртгийг тайлагнадаг. Орлогын тайлангийн бусад үзүүлэлтүүд болон хөрөнгө, өр төлбөрийн хувьд сегментийн мэдээлэл бэлтгэдэггүй.

**2.15 Холбоотой талууд**

Компани болон түүнтэй холбоотой этгээдүүдийн хооронд нөөц, ажил үйлчилгээ эсвэл үүрэг хариуцлага шилжүүлэхдээ төлбөр нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд хийгдсэн ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ. Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд Компанитай холбоотой гэж үзнэ.

- Компанийн шууд эсвэл хамтран хянадаг; эсвэл
- Компанийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг; эсвэл
- Компанийн болон Толгой Компанийн удирдах ажилтан.

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгжийг Компанитай холбоотой гэж үзнэ:

- Тухайн аж ахуйн нэгж болон Компани нь нэг бүлэг аж ахуйн нэгжийн бүрэлдэхүүнд багтаж байвал өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанид багтдаг охин компаниуд бүгд бусадтайгаа холбоотой гэсэн үг юм.
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан бүлгийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол;
- Хоёр компани хоёулаа нэг гуравдагч этгээдийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан үйлдвэр ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани бол;
- Тухайн аж ахуйн нэгж нь дээр дурьдсан холбоотой талаар тодорхойлогдсон хувь хүний шууд эсвэл хамтарсан хяналтан дор байх;
- Компанийг шууд эсвэл хамтран хянадаг этгээд нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөөтэй байх, тухайн аж ахуйн нэгжийн, эсвэл түүний толгой Компанийн удирдах ажилтан.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**2. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй (үргэлжлэл)**

**2.16 Татвар**

Орлогын татварын зардал нь тухайн жилд төлөхөөр тооцсон татвар ба хойшлогдсон татварын нийлбэрээс бүрдэнэ.

**2.16.1 Тайлант жилийн орлогын албан татвар**

Тухайн жилийн татварын өглөг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод суурилсан байна. Татвар ногдуулах орлого нь дэлгэрэнгүй орлогын тайлангаар тодорхойлсон ашгаас зөрүүтэй байдаг нь санхүүгийн тайланд тусгагдсан орлого, зарлагын зүйлсийн татвар ногдох, татвар ногдох орлогоос хасагдах хугацаа нь татварын тайлангийн зорилгоор өөр тайлант хугацаанд үүсдэг эсвэл эдгээр нь огт татвар ногдохгүй эсвэл татвар ногдох орлогоос хасагдахгүй байдагтай холбоотой. Компанийн тухайн жилийн татварын өрийг тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно.

**2.16.2 Хойшлогдсон татвар**

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдуулах орлогыг тооцоход хэрэглэсэн тэдгээрийн татварын суурь хоёрын хоорондын түр зөрүүнд тооцдог. Ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүгээр хойшлогдсон татварын өрийг бүртгэдэг. Хойшлогдсон татварын хөрөнгийг бараг бүх хасагдах түр зөрүүнд тооцдог боловч ирээдүйд тэдгээр хасагдах түр зөрүүг шингээхэд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх өндөр магадлалтай эсэхийг харгалздаг.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэст хянаж үздэг ба уг хөрөнгийг болон хөрөнгийн зарим хэсгийг нөхөхөд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх магадлал бага болсон бол дансны үнийг бууруулдаг. Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг борлуулах, барагдуулах үеийн татварын хувийг ашиглан хэмжих ба тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр (мөн татварын хуулиар) тооцож, тодорхойлно. Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг хэмжихдээ уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг тайлангийн өдрийн байдлаар Компани хэрхэн борлуулах, барагдуулахаар төлөвлөж байгаа ба түүнээс хамаарсан татварын нөлөөллийг тусгасан байх ёстой.

**2.16.3 Тайлант жилийн болон хойшлогдсон татвар**

Тухайн жилийн болон хойшлогдсон татварыг тайлант жилийн ашиг алдагдлаар бүртгэх ба харин тэдгээр нь дэлгэрэнгүй орлого эсвэл өмчийн хэсэгт шууд бүртгэгдсэн зүйлстэй холбоотой бол харгалзан дэлгэрэнгүй орлого эсвэл өмчийн хэсэгт бүртгэдэг.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**3. Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж**

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөрийн дүн, болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн тодруулга болон тайлант үед хүлээн зөвшөөрөгдсөн орлого, зардлын дүнд тус тус нөлөөлдөг. Ирээдүйд гарах бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг өөрчлөлт хийгдсэн тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдэд тус тус тусгадаг.

**3.1 Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж**

*3.1.1 Монгол улсын татварын систем*

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монголын Засгийн Газар бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт шинэчлэлтийг хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.

Өөр өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Компани татварын хууль тогтоомжийн ойлголт дээрээ үндэслэн бүх татваруудыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн Компанид татварын эрсдэл байсаар байна.

**3.2 Тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж**

Тайлант үеийн эцэст, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн их хэмжээний дүнгүүдтэй холбоотой дараах үндсэн таамаглалуудыг тодорхой бус байдлын тооцоололд ашигласан.

*3.2.1 Алдагдлын нөөц сангийн тооцоолол*

Компани дансны ба бусад авлагын хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо матрицын үнэлгээний аргыг ашигласан. Нөөц сан тооцоолох тусгайлсан арга нь Компанийн түүхэн дефавлтын түвшинд суурилдаг бөгөөд хэт их зардал болон өндөр хүчин чармайлт, өртөг шаардахааргүйгээр олж авах боломжтой ирээдүйг таамаглаж буй мэдээллүүдийг харгалзан үздэг. Тайлант үе бүрийн эцэст ажиглагдах түүхэн дефавлтын түвшинг дахин үнэлэх ба ингэхдээ ирээдүйг таамаглаж буй мэдээлэлд гарсан өөрчлөлтүүдийг авч үзнэ.

2023 оны 12 сарын 31-нээрх Компанийн дансны ба бусад авлагын цэвэр дансны үнэ нь 3,683,893 мянган төгрөг (2022: 6,122,274 мянган төгрөг) ба авлагын хүлээгдэж буй алдагдлын нөөц сан 357,765 мянган төгрөг (2022: 14,425 мянган төгрөг) байсан.

*3.2.2 Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил*

Тодруулга 2.5-д дурдсанчилан Компани үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцооллыг санхүүгийн тайлангийн өдрөөр хянадаг ба хэрэглээ, хөрөнгийн насжилт болон технологийн дэвшлээс харгалзан тооцооллыг өөрчлөх шаардлагатай бол залруулдаг. Тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцоололд өөрчлөлт гараагүй. Эдгээр тооцоололд гарч болзошгүй өөрчлөлт нь тухайн жилийн ашигт ихээхэн нөлөөлж болзошгүй.

Удирдлага дээрх тооцоолсон үндсэн хөрөнгийн ашиглалтын жилүүд нь уг хөрөнгийн бодитой эдийн засгийн ашиглах жил гэдэгт итгэж байна.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**4. Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)**

**4.1 Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн шинэчлэгдсэн СТОУС болон шинэ тайлбарууд**

Компани нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан 2023 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн СТОУС-ын өөрчлөлтүүдийг тайлант жилд хэрэгжүүлсэн.

Хэрэгжиж эхэлсэн хугацаа	Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд
2023 оны 1 сарын 1	<ul style="list-style-type: none"> <li>• СТОУС 17 Даатгалын гэрээ (2020 оны 6-р сар болон 2021 оны 12-р сард СТОУС 17-д орсон өөрчлөлтүүд)</li> <li>• НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга болон СТОУС Практик тайлагнал 2 Материаллаг байдлын дүгнэлт хийх-д орсон нэмэлт өөрчлөлтүүд - Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулах нь</li> <li>• НББОУС 12 Орлогын татвар-т орсон нэмэлт өөрчлөлтүүд - Нэг гүйлгээнээс үүссэн хөрөнгө болон өр төлбөрт холбогдох хойшлогдсон татвар</li> <li>• НББОУС 12 Орлогын татвар-т орсон нэмэлт өөрчлөлтүүд - Олон улсын татварын шинэчлэл-Хоёр тулгуурт загварын зарчим</li> <li>• НББОУС 8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа-д орсон нэмэлт өөрчлөлтүүд - Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт</li> </ul>

Дээр дурдсан стандартуудын хэрэгжилт нь Компанийн санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлогын тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудад нөлөө үзүүлээгүй болно.

**4.2 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй шинэчлэгдсэн СТОУС болон шинэ тайлбарууд**

Компанийн санхүүгийн тайлангуудыг батлан гаргах үед батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон тайлбаруудыг доор тодруулсан болно. Эдгээр стандартууд болон өөрчлөлтүүдийг Компани хэрэгжиж эхлэх үеэс дагаж мөрдөнө.

Хэрэгжиж эхлэх хугацаа	Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд
2024 оны 1 сарын 1	<ul style="list-style-type: none"> <li>• НББОУС 1-т орсон нэмэлт өөрчлөлтүүд - Эргэлтийн ба эргэлтийн бус өр төлбөрийн ангилал</li> <li>• НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга-т орсон нэмэлт өөрчлөлтүүд - Гэрээгээр хүлээсэн үүрэгтэй урт хугацаат өр төлбөр</li> <li>• НББОУС 7 Мөнгөн гүйлгээний тайлан болон СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга-т орсон нэмэлт өөрчлөлтүүд - Нийлүүлэгчийн санхүүгийн хэлцэл</li> <li>• СТОУС 16 Түрээс-д орсон нэмэлт өөрчлөлтүүд - Борлуулаад эргүүлэн түрээслэх түрээсийн өр төлбөр</li> </ul>
Тодорхойгүй	<ul style="list-style-type: none"> <li>• СТОУС 10 болон НББОУС 28-т орсон нэмэлт өөрчлөлтүүд Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани, хамтарсан компанийн хооронд худалдсан эсвэл хандивласан хөрөнгө</li> </ul>

Компанийн удирдлага нь эдгээр шинэ болон шинэчилсэн СТОУС-ыг нэвтрүүлэх явцад хяналт тавин ажиллаж байна Санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг тодорхойлж дуусаагүй байгаа тул Компани нарийвчилсан хяналтыг хийж дуустал эдгээр шинэ болон шинэчилсэн СТОУС-ын үр нөлөөг бодитойгоор тооцоолох боломжгүй байна.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**5. Сегментийн тайлагнал**

	Сегментийн орлого		Сегментийн ашиг	
	2023	2022	2023	2022
Жижиглэн худалдааны харилцагчид	7,887,235	7,800,139	3,446,667	2,846,260
Зах болон бөөний төвүүд	10,055,575	9,047,142	4,199,666	2,842,428
Хөдөө орон нутгийн гэрээт борлуулагчид	4,205,276	4,478,971	1,773,150	1,169,149
Сүлжээ дэлгүүрүүд	6,229,872	5,318,710	2,677,662	1,796,912
Нэрийн дэлгүүрүүд	2,954,052	2,353,227	1,081,765	719,182
Агуулах худалдаа	2,870,721	1,133,283	1,305,956	283,413
Үзэсгэлэн	109,479	22,294	47,434	8,530
<b>Нийт ашиг</b>	<b>34,312,210</b>	<b>30,153,766</b>	<b>14,532,300</b>	<b>9,665,874</b>

**6. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

	2023	2022
Харилцах дансан дахь мөнгө	18,207,671	1,367,291
Богино хугацаатай хадгаламж	1,500,000	-
Касс дахь мөнгө	355,273	418,601
	<b>20,062,944</b>	<b>1,785,892</b>

Богино хугацаатай хадгаламж нь бэлэн мөнгө болон хөрвөхөд бэлэн бөгөөд үнийн дүнд өөрчлөлт орох эрсдэлгүй, богино хугацаатай, хөрвөх чадвар өндөртэй, жилийн 10-10.5% хүүтэй хадгаламж юм.

**7. Дансны ба бусад авлага**

	2023	2022
Дансны авлага	3,466,653	2,358,303
Холбоотой талаас авах авлага (Тодруулга 22.1)	-	3,252,776
Бусад татварын авлага	159,836	120,240
Бусад авлага	415,169	405,380
	<b>4,041,658</b>	<b>6,136,699</b>
Авлагын хүлээгдэж буй алдагдлын нөөц сан	(357,765)	(14,425)
	<b>3,683,893</b>	<b>6,122,274</b>

**7.1 Авлагын хүлээгдэж буй алдагдлын нөөц сан**

Хугацаа хэтэрсэн авлагад хүү тооцдоггүй. Аливаа шинэ харилцагчийг хүлээн зөвшөөрөхөөс өмнө Компанийн удирдлага харилцагчийн зээлийн эрсдлийн чанарыг үнэлэн зээлийн хязгаарыг харилцагч тус бүрийн хувьд тодорхойлдог.

Компани дансны авлагын алдагдлын нөөц санг бүртгэхдээ нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдлыг тооцоолдог. Тайлагналын өдрөөр авлагын хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо алдагдлын түүхэн мэдээлэл, тухайн зээлдэгчид тусгайлан хамааралтай хүчин зүйлс, үндсэн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн орчин, одоогийн болон ирээдүйг таамаглаж буй мэдээллийг харгалзан тохируулсан нөөц сан тооцоолох матрицыг (үнэ цэнэ нь буураагүй авлагуудад) болон тусгайлан үнэлгээний аргыг (үнэ цэнэ буурсан авлагад) ашигладаг.



**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**7. Дансны ба бусад авлага**

**7.1 Авлагын хүлээгдэж буй алдагдлын нөөц сан (үргэлжлэл)**

Тооцооллын арга аргачлал болон нөлөө үзүүлэхүйц таамаглалуудад тайлант жилд өөрчлөлт ороогүй болно.

	<b>Нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдал</b>		
	<b>Үнэ цэнэ буураагүй</b>	<b>Үнэ цэнэ буурсан</b>	<b>Нийт</b>
<b>2021 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>14,425</b>	<b>14,425</b>
Тайлант жилд байгуулсан үнэ цэнийн бууралт	-	50,000	50,000
Данснаас хассан авлага	-	(50,000)	(50,000)
<b>2022 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>14,425</b>	<b>14,425</b>
Тайлант жилд байгуулсан үнэ цэнийн бууралт	-	1,712,903	1,712,903
Данснаас хассан авлага	-	(1,369,563)	(1,369,563)
<b>2023 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>357,765</b>	<b>357,765</b>

**8. Урьдчилгаа төлбөр**

	<b>2023</b>	<b>2022</b>
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа	3,349,696	2,854,045
Урьдчилж төлсөн зардал	19,161	3,435
	<b>3,368,857</b>	<b>2,857,480</b>

**9. Бараа материал**

	<b>2023</b>	<b>2022</b>
Түүхий эд материал	5,466,474	5,646,101
Хангамжийн материал	748,161	461,698
Бэлэн бүтээгдэхүүн	5,237,045	4,797,053
	<b>11,451,680</b>	<b>10,904,852</b>

Бараа материалын өртгөөс борлуулсан бүтээгдэхүүний өртөг болон үйл ажиллагааны зардалд 19,779,910 мянган төгрөг ба 127,253 мянган төгрөг (2022 оны 12 сарын 31: 20,487,892 мянган төгрөг ба 40,080 мянган төгрөг) тус тус бүртгэсэн.

Тайлант жилд Компани 2,531,494 мянган төгрөгийн цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлийг (2022 оны 12 сарын 31: 2,145,631 мянган төгрөг) бараа материалын өртөгт капиталжуулж бүртгэсэн.

ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

10. Үндсэн хөрөнгө

	Газар	Барилга байгууламж	Тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд		Компьютер	Дуусаагүй барилга	Бусад	Нийт
					хогшил	хогшил				
<b>Өртөг:</b>										
2021 оны 12 сарын 31	15,000	3,786,273	4,869,213	1,080,009	175,106	-	95,316	-	189,662	10,210,579
Нэмэгдсэн	5,097	193,469	377,000	173,411	1,476	-	7,481	-	142,863	900,797
Хасагдсан	-	(193,469)	-	(110,351)	(2,537)	-	-	-	(34,961)	(341,318)
<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>20,097</b>	<b>3,786,273</b>	<b>5,246,213</b>	<b>1,143,069</b>	<b>174,045</b>	<b>-</b>	<b>102,797</b>	<b>-</b>	<b>297,564</b>	<b>10,770,058</b>
Ангилал өөрчилсөн	-	3,776	38,135	(52,976)	52,820	-	26,658	-	(68,413)	-
Нэмэгдсэн	485,662	-	347,612	460,270	35,687	-	75,047	135,098	52,960	1,592,336
Хасагдсан	-	-	(128,954)	(124,783)	(26,203)	-	(3,988)	-	(29,414)	(313,342)
<b>2023 оны 12 сарын 31</b>	<b>505,759</b>	<b>3,790,049</b>	<b>5,503,006</b>	<b>1,425,580</b>	<b>236,349</b>	<b>-</b>	<b>200,514</b>	<b>135,098</b>	<b>252,697</b>	<b>12,049,052</b>
<b>Хуримтлагдсан элэгдэл:</b>										
2021 оны 12 сарын 31	-	355,186	1,771,460	208,354	45,358	-	85,872	-	83,633	2,549,863
Элэгдэл	-	153,419	482,463	104,592	17,108	-	9,632	-	29,270	796,484
Хасагдсан	-	(2,084)	-	(35,932)	(376)	-	-	-	(12,562)	(50,954)
<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>-</b>	<b>506,521</b>	<b>2,253,923</b>	<b>277,014</b>	<b>62,090</b>	<b>-</b>	<b>95,504</b>	<b>-</b>	<b>100,341</b>	<b>3,295,393</b>
Ангилал өөрчилсөн	-	831	(16,128)	(8,399)	7,660	-	26,594	-	(10,558)	-
Элэгдэл	-	151,486	490,702	135,217	22,945	-	6,289	-	41,966	848,605
Хасагдсан	-	-	(121,667)	(69,698)	(16,095)	-	(3,332)	-	(18,741)	(229,533)
<b>2023 оны 12 сарын 31</b>	<b>-</b>	<b>658,838</b>	<b>2,606,830</b>	<b>334,134</b>	<b>76,600</b>	<b>-</b>	<b>125,055</b>	<b>-</b>	<b>113,008</b>	<b>3,914,465</b>
<b>Дансны үнэ:</b>										
<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>20,097</b>	<b>3,279,752</b>	<b>2,992,290</b>	<b>866,055</b>	<b>111,955</b>	<b>-</b>	<b>7,293</b>	<b>-</b>	<b>197,223</b>	<b>7,474,665</b>
<b>2023 оны 12 сарын 31</b>	<b>505,759</b>	<b>3,131,211</b>	<b>2,896,176</b>	<b>1,091,446</b>	<b>159,749</b>	<b>-</b>	<b>75,459</b>	<b>135,098</b>	<b>139,689</b>	<b>8,134,587</b>

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**10. Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)**

**10.1 Барьцаалсан үндсэн хөрөнгө**

2023 оны 12 сарын 31-ний байдлаар 1,496 сая төгрөг (2022: 1,757 сая төгрөгийн) дансны үнэтэй барилга болон газар эзэмших эрхийг банкны зээлэнд барьцаалсан байна.

**10.2 Бүрэн элэгдсэн үндсэн хөрөнгө**

	<b>2023</b>	<b>2022</b>
Өртөг	267,574	246,553
	<b>267,574</b>	<b>246,553</b>

**10.3 Ашиг, алдагдал болон бараа материалаар бүртгэсэн элэгдэл, хорогдол**

Борлуулалт болон ерөнхий удирдлагын зардлаар бүртгэсэн элэгдэл ба хорогдол:

	<b>2023</b>	<b>2022</b>
Биет хөрөнгийн элэгдэл	319,392	163,922
Биет бус хөрөнгийн хорогдол	31,324	7,482
	<b>350,716</b>	<b>171,404</b>

Тайлант жилд Компани 529,213 мянган төгрөгийн (2022 оны 12 сарын 31: 632,562 мянган төгрөг) элэгдэл ба хорогдлын зардлыг бараа материалын өртөгт хүлээн зөвшөөрөн бүртгэсэн.

**11. Биет бус хөрөнгө**

	<b>Барааны тэмдэгт</b>	<b>Программ хангамж</b>	<b>Нийт</b>
<b>Өртөг:</b>			
2022 оны 1 сарын 1	-	11,404	11,404
Нэмэгдсэн	-	-	-
<b>2022 оны 12 сарын 31</b>	-	<b>11,404</b>	<b>11,404</b>
Нэмэгдсэн	3,300,000	73,720	3,373,720
<b>2023 оны 12 сарын 31</b>	<b>3,300,000</b>	<b>85,124</b>	<b>3,385,124</b>
<b>Хуримтлагдсан элэгдэл:</b>			
2022 оны 1 сарын 1	-	-	-
Элэгдэл	-	7,482	7,482
<b>2022 оны 12 сарын 31</b>	-	<b>7,482</b>	<b>7,482</b>
Элэгдэл	-	31,324	31,324
<b>2023 оны 12 сарын 31</b>	-	<b>38,806</b>	<b>38,806</b>
<b>Дансны үнэ:</b>			
<b>2022 оны 12 сарын 31</b>	-	<b>3,922</b>	<b>3,922</b>
<b>2023 оны 12 сарын 31</b>	<b>3,300,000</b>	<b>46,318</b>	<b>3,346,318</b>

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**12. Дансны ба бусад өглөг**

	<b>2023</b>	<b>2022</b>
Дансны өглөг	333,347	143,144
Татварын өглөг (орлогын татварын өглөг ороогүй)	374,424	324,710
Цалингийн өглөг	205,159	123,770
Бусад өглөг	19,784	1,619
	<b>932,714</b>	<b>593,243</b>

**13. Гэрээний өр төлбөр**

	<b>2023</b>	<b>2022</b>
Харилцагчаас хүлээн авсан урьдчилгаа	567,058	-
	<b>567,058</b>	<b>-</b>

**14. Зээл**

	<b>2023</b>	<b>2022</b>
Богино хугацаат	1,717,691	692,571
Урт хугацаат	5,603,354	1,586,210
	<b>7,321,045</b>	<b>2,278,781</b>

	<b>2023</b>	<b>2022</b>
Голомт банкнаас авсан зээл (i)	1,165,084	1,934,321
Голомт банкнаас авсан зээл (ii)	1,813,403	-
Голомт банкнаас авсан зээл (iii)	1,499,541	-
Голомт банкнаас авсан зээл (iv)	2,843,017	-
Хувь хүнээс авсан зээл (v)	-	344,460
	<b>7,321,045</b>	<b>2,278,781</b>

**14.1 Зээлийн гэрээний хураангуй**

- (i) Компани нь 2018 оны 5-р сарын 29-ний өдөр 4.6 тэрбум төгрөгийн зээлийг дарсан ногоо, дулааны аргаар боловсруулсан ногооны салатны нэмүү өртгийн сүлжээг өргөтгөх төслийн зорилгоор Голомт банкнаас жилийн 24 хувийн хүүтэй 84 сарын хугацаатай авсан. Монгол Улсын Сангийн Яам нь зээлдэгчид Хөдөө Аж Ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, хоршоодын нэмүү өртгийн сүлжээний хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогын хүрээнд, нийт зээлийн хүүгээс 16 хувийг нь хөнгөлж, дэмжлэг үзүүлсэн. Энэхүү хөнгөлөлттэй зээлийг засгийн газрын тусламжаар бүртгэсэн ба Тодруулга 14.3-г үзнэ үү. Уг зээлэнд Компанийн үндсэн хөрөнгийг барьцаалсан. Зээлийн эргэн төлөлт 2018 оны 6 сард эхэлсэн бөгөөд 2025 оны 5 сард зээлийг бүрэн төлж барагдуулна.
- (ii) Компани нь 2023 оны 6-р сарын 15-ний өдөр 2 тэрбум төгрөгийн зээлийг хүнс газар тариалангийн техник тоног төхөөрөмж, тусгай тээврийн хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Голомт банкнаас жилийн 18 хувийн хүүтэй 24 сарын хугацаатай авсан. Монгол Улсын Хүнс Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам ("ХХААХҮЯ") нь Компанид хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд, нийт зээлийн хүүгээс 13 хувийг нь хөнгөлж, дэмжлэг үзүүлсэн. Энэхүү хөнгөлөлттэй зээлийг засгийн газрын тусламжаар бүртгэсэн ба Тодруулга 14.3-г үзнэ үү. Уг зээлэнд Компанийн үндсэн хөрөнгийг барьцаалсан ба 2025 оны 6 сард бүрэн төлж барагдуулна.
- (iii) Компани нь 2023 оны 6-р сарын 15-ний өдөр 2 тэрбум төгрөгийн зээлийг хүнс газар тариалангийн техник тоног төхөөрөмж, тусгай тээврийн хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Голомт банкнаас жилийн 19 хувийн хүүтэй 60 сарын хугацаатай авсан. ХХААХҮЯ нь Компанид хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд, нийт зээлийн хүүгээс 13 хувийг нь хөнгөлж, дэмжлэг үзүүлсэн. Энэхүү хөнгөлөлттэй зээлийг засгийн газрын тусламжаар бүртгэсэн ба Тодруулга 14.3-г үзнэ үү. Уг зээлэнд Компанийн үндсэн хөрөнгийг барьцаалсан ба 2028 оны 6 сард бүрэн төлж барагдуулна.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**14. Зээл (үргэлжлэл)**

**14.1 Зээлийн гэрээний хураангуй**

- (iv) Компани нь 2023 оны 12-р сарын 27-ний өдөр 4 тэрбум төгрөгийн зээлийг төмс, хүнсний ногооны зоорь, агуулах шинээр байгуулах зорилгоор Голомт банкнаас жилийн 19 хувийн хүүтэй 60 сарын хугацаатай авсан. ХХААХҮЯ нь Компанид хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд, нийт зээлийн хүүгээс 13 хувийг нь хөнгөлж, дэмжлэг үзүүлсэн. Энэхүү хөнгөлөлттэй зээлийг засгийн газрын тусламжаар бүртгэсэн ба Тодруулга 14.3-г үзнэ үү. Уг зээлэнд Компанийн үндсэн хөрөнгийг барьцаалсан ба 2028 оны 12 сард бүрэн төлж барагдуулна.
- (v) Компани нь 2021 оны 1 сарын 8-ний өдөр хувь хүнээс 100,000 ам долларыг сарын нэг хувийн хүүтэй зээлсэн ба 2023 онд бүрэн төлж барагдуулсан.

**14.2 Санхүүжилтийн үйл ажиллагаанаас үүсэх өр төлбөрийг тохируулах нь**

	<b>Банкны зээл</b>	<b>Нийт</b>
2022 оны 1 сарын 1	2,753,525	2,753,525
Санхүүгийн дотогш мөнгөн урсгал	2,545,288	2,545,288
Санхүүгийн гадагш мөнгөн урсгал	(2,990,376)	(2,990,376)
Хүүгийн зардал	726,239	726,239
Төлсөн хүү	(417,176)	(417,176)
Хөнгөлттэй зээлийн хүүгийн хөнгөлөлт (Тодруулга 19)	(309,063)	(309,063)
Ханшийн зөрүү	(29,656)	(29,656)
<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>2,278,781</b>	<b>2,278,781</b>
Санхүүгийн дотогш мөнгөн урсгал	5,970,092	5,970,092
Санхүүгийн гадагш мөнгөн урсгал	(927,828)	(927,828)
Хүүгийн зардал	596,118	596,118
Төлсөн хүү	(182,819)	(182,819)
Хөнгөлттэй зээлийн хүүгийн хөнгөлөлт (Тодруулга 19)	(413,299)	(413,299)
<b>2023 оны 12 сарын 31</b>	<b>7,321,045</b>	<b>7,321,045</b>

**14.3 Хөнгөлөлттэй зээлүүд дээр тооцоологдсон хойшлогдсон орлого**

	<b>2023</b>	<b>2022</b>
Богино хугацаат	785,642	227,429
Урт хугацаат	1,196,646	138,250
	<b>1,982,288</b>	<b>365,679</b>

Компани нь 2018 болон 2023 онуудад Засгийн Газраас хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээлүүд авсан ба зах зээлийн хүүгээс бага хүүтэй эдгээр зээлүүдийг СТОУС 9-ийн дагуу зээлийн бодит үнэ цэнээр нь бүртгэлд тусгасан. Зээлийг анх хүлээн зөвшөөрөх үеийн зээлийн бодит үнэ цэнэ ба хүлээн авсан дүнгийн зөрүүгээр хойшлогдсон орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн ба уг хөнгөлөлтийг зээлийн хугацааны туршид хорогдуулан, бусад орлогоор бүртгэнэ. Тайлант жилд хорогдуулан бүртгэсэн бусад орлогыг Тодруулга 19-с харна уу.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**15. Хувьцаат капитал**

	Хувьцааны тоо		Хувьцаат капитал (мянган төгрөг)	
	2023	2022	2023	2022
Эхний үлдэгдэл	1,000,000,000	1,000,000,000	110,000	110,000
Нэмж гаргасан хувьцаа	198,113,207	-	21,792	-
Эцсийн үлдэгдэл	<b>1,198,113,207</b>	<b>1,000,000,000</b>	<b>131,792</b>	<b>110,000</b>

2023 оны байдлаар Компани нэг бүр нь 0.11 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,198,113,207 ширхэг хувьцаанаас бүрдсэн, 131,792 мянган төгрөг (2022: 0.11 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,000,000,000 ширхэг хувьцаанаас бүрдсэн, 110,000 мянган төгрөг)-ийн хувьцаат капиталтай байна.

Компани нь 2023 оны 2 сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолоор нэгж хувьцаанд 3.3 төгрөгийн, нийт 3,300,000 мянган төгрөгийн ногдол ашиг зарлаж, тараасан.

Тус компани нь Улсын бүртгэлийн ерөнхий газарт 2577127 регистрийн дугаараар бүртгэлтэй.

**15.1 Нэгж хувьцаанд ногдох ашиг**

Нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг энгийн хувьцаа эзэмшигчид ногдуулсан ба энгийн хувьцааны жигнэсэн дунджаар дараах байдалтай байна.

	2023	2022
Тайлант жилийн ашиг	6,536,543	4,150,746
Энгийн хувьцааны тоо	1,198,113,207	1,000,000,000
Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр)	<b>5.46</b>	<b>4.15</b>

**16. Нэмж төлөгдсөн капитал**

	2023	2022
Нэмж төлөгдсөн капитал	9,848,102	-
	<b>9,848,102</b>	<b>-</b>

Компани нь 2023 оны 4-р сард нээлттэй хувьцаат компани болж Монгол улсын хөрөнгийн биржид бүртгэгдсэн. Нийт эргэлтэнд байгаа энгийн хувьцааны 16.54 хувь буюу 198,113,207 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгон нийт 10.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татан төвлөрүүлсэн. Нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн хэмжээ болох 10.5 тэрбум төгрөгөөс хувьцаа гаргалттай холбоотой гарсан 630,105 мянган төгрөгийн зардлыг хассан дүнгээр нэмж төлөгдсөн капиталыг хүлээн зөвшөөрсөн.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**17. Орлогын татварын зардал**

	2023	2022
<b>Тайлант жилийн татварын зардал:</b>		
Тайлант жилийн орлогын татварын зардал	1,222,362	515,183
<b>Хойшлогдсон татварын зардал:</b>		
Тайлант жилд тооцсон хойшлогдсон татварын (өгөөж)/зардал	(9,087)	7,552
	<b>1,213,275</b>	<b>522,735</b>

**17.1 Тайлант жилийн татвар**

Тайлант жилийн татварын зардлыг санхүүгийн тайлангаарх цэвэр ашгаас тооцсон тохируулга:

	2023	2022
Санхүүгийн тайлангаарх татварын өмнөх цэвэр ашиг	7,749,818	4,673,481
Татварын өмнөх ашгаас татварын хувь хэмжээгээр тооцсон татварын зардал	1,937,455	1,168,370
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нөлөөлөл	438,884	265,553
Тусгай хувь хэмжээгээр тооцсон орлогын нөлөөлөл	(28,967)	(1,626)
Татварын хөнгөлөлт	(234,097)	(9,562)
Татварын бага хувийн нөлөөлөл	(900,000)	(900,000)
<b>Тайлант жилийн татварын зардал</b>	<b>1,213,275</b>	<b>522,735</b>

2023 болон 2022 оны дээрх татварын тохируулгыг Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу 6 тэрбум төгрөг хүртэлх албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 6 тэрбум төгрөгөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж албан татвар ногдуулсан.

**17.2 Орлогын татварын өглөг**

	2023	2022
Орлогын татварын өглөгийн эхний үлдэгдэл	174,750	526,874
Тайлант жилийн орлогын татварын зардал	1,222,362	515,183
Төлсөн орлогын татвар	(605,920)	(867,307)
Орлогын татварын өглөгийн эцсийн үлдэгдэл	<b>791,192</b>	<b>174,750</b>

**17.3 Хойшлогдсон татварын үлдэгдэл**

	Хойшлогдсон татварын хөрөнгө/(өр төлбөр)		Ашиг, алдагдлаар бүртгэсэн дүн	
	2023	2022	2023	2022
Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн зөрүүний нөлөөлөл	1,535	-	(1,535)	-
Гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрөөс үүссэн	-	(7,552)	(7,552)	7,552
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>1,535</b>	<b>(7,552)</b>	<b>(9,087)</b>	<b>7,552</b>

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**18. Борлуулалтын орлого ба борлуулсан бүтээгдэхүүний өртөг**

**18.1 Борлуулалтын орлого**

	<b>2023</b>	<b>2022</b>
Борлуулалтын орлого	34,670,750	30,470,039
Борлуулалтын буцаалт	(73,497)	(88,198)
Борлуулалтын хөнгөлөлт	(285,043)	(228,075)
	<b>34,312,210</b>	<b>30,153,766</b>

**18.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг**

	<b>2023</b>	<b>2022</b>
Борлуулалтын өртөг	19,779,910	20,487,892
	<b>19,779,910</b>	<b>20,487,892</b>

**19. Бусад орлого**

	<b>2023</b>	<b>2022</b>
Хүүгийн орлого	193,117	10,841
Хөнгөлөлттэй зээлийн хүүгийн хорогдуулалтаас үүссэн орлого (Тодруулга 14)	413,299	309,063
Бусад орлого	73,957	92,572
	<b>680,373</b>	<b>412,476</b>

**20. Ерөнхий ба удирдлагын зардал**

	<b>2023</b>	<b>2022</b>
Цалин болон түүнтэй адилтгах зардлууд	2,440,906	2,020,822
Элэгдлийн зардал	350,716	171,404
Мэргэжлийн ажил, үйлчилгээний зардал	289,462	420,400
Зар сурталчилгааны зардал	216,553	145,037
Шатахууны зардал	200,906	191,988
Тээврийн зардал	156,825	154,026
Засвар үйлчилгээний зардал	110,666	117,498
Банкны шимтгэлийн зардал	97,067	14,283
Баяр ёслолын зардал	91,431	65,780
Томилолтын зардал	90,766	38,640
Бараа материалын хорогдолын зардал	80,684	25,923
Бусад татварын зардал	63,891	61,334
Түрээсийн зардал	50,981	40,222
Ашиглалтын зардал	50,022	52,715
Хангамжийн зардал	42,735	36,554
Харилцаа холбооны зардал	19,695	24,025
Ажилтны сургалт	18,585	11,639
Даатгалын зардал	13,065	2,114
Хүү, торгуулийн зардал	490	306
Бусад зардал	717,701	980,138
	<b>5,103,147</b>	<b>4,574,848</b>



**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**21. Бусад олз ба (гарз)**

	<b>2023</b>	<b>2022</b>
Ханшийн зөрүүгийн алдагдал	(26,476)	(37,016)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	(24,211)	(16,766)
	<b>(50,687)</b>	<b>(53,782)</b>

**22. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл**

**22.1 Холбоотой талуудын үлдэгдэл**

2023 болон 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар Компани нь дараах үлдэгдэл болон холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээтэй байсан:

	<b>2023</b>	<b>2022</b>
<b>Холбоотой талуудын үлдэгдэл:</b>		
Хувьцаа эзэмшигчдээс авах авлага	-	2,406,481
Бусад холбоотой талуудаас авах авлага	-	846,295

**22.2 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба хэлцлийн нөхцөл**

*Дараах ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн.*

	<b>2023</b>	<b>2022</b>
Зарласан ногдол ашиг	3,300,000	-
Ногдол ашгаас төлсөн	3,300,000	1,050,000
Авсан санхүүжилтээс төлсөн	380,000	-
Худалдаж авсан үндсэн хөрөнгө	311,700	-
Худалдаж авсан биет бус хөрөнгө	3,300,000	-

Дээр дурдсан ажил гүйлгээ болон үлдэгдэл нь бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад үүссэн. Холбоотой талуудтай хийсэн худалдан авалтад хүү тооцдоггүй.

**22.3 Үндсэн удирдлагын цалин хөлс, урамшуулал**

Үндсэн удирдлагын гишүүд болон захирлуудын цалин, урамшуулал дараах байдалтай байна:

	<b>2023</b>	<b>2022</b>
Цалин болон богино хугацаат урамшуулал	173,068	142,616
	<b>173,068</b>	<b>142,616</b>

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**23. Санхүүгийн хэрэгсэлүүд ба санхүүгийн эрсдэлийн удирдлага**

Компанийн санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг багасгахын тулд зээлийн, хөрвөх чадвар, хүүгийн болон валютын ханшийн эрсдэлийг удирдахын зэрэгцээ Компанийн бизнесийг хөгжүүлэхэд хангалттай санхүүгийн эх үүсвэрийг бий болгоход чиглэгддэг. Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан тодорхой заасан удирдамжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Компанийн санхүүгийн үндсэн хэрэгслүүд нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, дансны ба бусад авлага, банкны зээл болон дансны ба бусад өглөгөөс бүрдэнэ. Эдгээр санхүүгийн хэрэгслийн гол зорилго нь Компанийн үйл ажиллагаанд санхүүжилт босгох явдал юм.

**Санхүүгийн хэрэгслийн ангилал:**

	<b>2023</b>	<b>2022</b>
<b>Санхүүгийн хөрөнгө :</b>		
Банкин дах мөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгө, хорогдуулсан өртгөөр	19,707,671	1,367,291
Дансны ба бусад авлага, хорогдуулсан өртгөөр	3,524,057	6,002,034
<b>Санхүүгийн өр төлбөр:</b>		
Дансны ба бусад өр төлбөр, хорогдуулсан өртгөөр	353,131	144,763
Зээл, хорогдуулсан өртгөөр	7,321,045	2,278,781

Компани нь үйл ажиллагаагаа санхүүжүүлэхийн тулд эдгээр санхүүгийн хэрэгслүүдийг эзэмшдэг. Компани арилжаалах болон санхүүгийн хамгаалалт хийх зорилгоор санхүүгийн хэрэгслүүдийг эзэмшдэггүй болно.

Компанийн санхүүгийн хэрэгслээс үүсэлтэй үндсэн эрсдэлүүдийг зээлийн эрсдэл болон төлбөрийн чадварын эрсдэл гэж ангилдаг.

**23.1 Зээлийн эрсдэлийн удирдлага**

Компанийн харилцагчид зээлийн нөхцлөөр худалдан авалт хийгээд түүнийгээ төлж чадахгүй болсноор Компанид санхүүгийн хохирол учрах зээлийн эрсдлийг үүсгэдэг.

2023 болон 2022 оны 12-р сарын 31-ний байдлаарх зээлийн эрсдэл:

	<b>Дансны үнэ</b>	
	<b>2023</b>	<b>2022</b>
Банкин дахь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	19,707,671	1,367,291
Дансны ба бусад авлага, хорогдуулсан өртгөөр	3,524,057	6,002,034
	<b>23,231,728</b>	<b>7,369,325</b>

Компани тайлант хугацааны эцсээрх дансны ба бусад авлагад барьцаа аваагүй. Компанийн удирдлага нь өндөр зээлийн зэрэглэлтэй дотоодын банк болон санхүүгийн байгууллагуудад байршуулсан банкны харилцах дансанд харгалзах санхүүгийн зээлийн эрсдлийн түвшинг бага гэж үзсэн. Компанийн удирдлага нь дефолтын магадлал нь бага гэж үзсэн тул нөөц санг байгуулаагүй.

Компанийн удирдлагууд түүхэн тооцооны бүртгэлд үндэслэн дансны ба бусад авлагын эргэн төлөгдөх чадварын талаар хувь хүний үнэлгээ хийж, хэтийн төлөвийн мэдээллээр тохируулсан. Компани нь эдгээр зүйлийн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг одоогийн нөхцөл байдал, ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлын тооцооллыг тусгах үүднээс зохих ёсоор тохируулсан зээлдэгчийн хугацаа хэтэрсэн байдалд үндэслэн зээлийн алдагдлын түүхэн туршлагад үндэслэн тодорхойлдог. Дансны ба бусад авлагын үнэ цэнийн бууралтын үнэлгээний дэлгэрэнгүйг Тодруулга 7-д тусгасан болно.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**23. Санхүүгийн хэрэгсэлүүд ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**23.1 Зээлийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь Компани өөрийн санхүүгийн өр төлбөрийг барагдуулах үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй болох эрсдэл юм. Компани нь хэвийн болон онцгой нөхцөлд их хэмжээний алдагдалд орохгүйгээр, Компанийн нэр хүндэд хохирол учруулах эрсдэлийг бий болгохгүйгээр өр төлбөрөө гэрээний хугацаанд төлж барагдуулахад хүрэлцэхүйц хөрвөх чадварыг байнга барьж байх ёстой гэдэг зарчмаар хөрвөх чадварыг удирдан зохицуулдаг.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хөрвөх чадварын эрсдлийн удирдлагыг хариуцдаг ба Компанийн богино, дунд ба урт хугацааны санхүүжилт болон хөрвөх чадварын эрсдлийн удирдлагын шаардлагад нийцсэн хөрвөх чадварын бүтцийг бий болгох үүрэгтэй. Компани санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн төлөгдөх хугацаа, банкнаас зээл авах чадавхи, зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл, мөнгөн урсгалын таамаглал болон гүйцэтгэлд үндэслэн хөрвөх чадварын эрсдлийг удирддаг.

Хүснэгтэнд Компанийн дериватив бус санхүүгийн өр төлбөрийг гэрээгээрх төлөх хугацаагаар нь ангилан тайлагнасан. Хүснэгтэн дэх мэдээлэл нь Компанийн төлбөр төлөх шаардлагатай хамгийн эхний хугацаанд үндэслэсэн дискаунтлаагүй мөнгөн гүйлгээг харуулж байна. Энэхүү хүснэгтийн дүнгүүд нь үндсэн төлбөр болон хүүг агуулсан болно. Эргэн төлөгдөх хугацааг тодорхойлохдоо Компаниас төлбөр төлөхийг шаардаж болзошгүй хамгийн эхний хугацааг үндэслэсэн болно.

ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

23. Санхүүгийн хэрэгсэлүүд ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

23.2 Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

Жигнэсэн дундаж хүүгийн түвшин	3 сараас бага	3-6 сар	6 сараас 1 жил	1-3 жил	3-аас дээш жил	Нийт	Дансны үнэ
Хүүгүй хэрэглүүр	353,131	-	-	-	-	353,131	353,131
Тогтмол хүүтэй хэрэглүүр	701,163	693,774	1,606,645	6,208,370	1,286,993	10,496,945	7,321,045
	<b>1,054,294</b>	<b>693,774</b>	<b>1,606,645</b>	<b>6,208,370</b>	<b>1,286,993</b>	<b>10,850,076</b>	<b>7,674,176</b>

Жигнэсэн дундаж хүүгийн түвшин	3 сараас бага	3-6 сар	6 сараас 1 жил	1-3 жил	3-аас дээш жил	Нийт	Дансны үнэ
Хүүгүй хэрэглүүр	144,763	-	-	-	-	144,763	144,763
Тогтмол хүүтэй хэрэглүүр	702,987	268,648	523,047	1,381,654	-	2,876,336	2,278,781
	<b>847,750</b>	<b>268,648</b>	<b>523,047</b>	<b>1,381,654</b>	<b>-</b>	<b>3,021,099</b>	<b>2,423,544</b>

23.3 Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлт тухайлбал хүүгийн хувь, гадаад валютын ханш өөрчлөгдсөнөөр Компанийн орлого эсвэл эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээнд сөргөөр нөлөөлөх эрсдэл юм. Компани зах зээлийн үндсэн эрсдэл болох хүүгийн эрсдэл болон гадаад валютын эрсдлийг дараах дурдсанаар хянаж удирддаг.

Зах зээлийн эрсдлийн удирдлагын зорилго нь параметруудийг зөвшөөрөгдөх хэмжээнд барих, эрсдлийг бууруулахын тулд зах зээлийн эрсдлийг удирдах, хянах явдал юм.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**23. Санхүүгийн хэрэгсэлүүд ба санхүүгийн эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**

**23.3 Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

**23.3.1 Зээлийн хүүгийн эрсдэлийн удирдлага**

Компани нь 2023 болон 2022 оны 12 сарын 31-нээр зөвхөн тогтмол хүүтэй зээлтэй байсан учраас зээлийн хүүгийн эрсдэл байхгүй. Зээлийн хүүгийн эрсдлийг удирдахдаа хамгаалалтын хэрэглүүрийг ашигладаггүй.

Компанийн удирдлага хүүгийн түвшингийн өөрчлөлт нь хадгаламж болон харилцах дансны хүүгийн орлогод нөлөөлөөгүй учраас шинжилгээ бэлтгээгүй болно.

**23.3.2 Гадаад валютын эрсдэлийн удирдлага**

Компанид төгрөгөөс өөр валютаар үүссэн худалдан авалт болон төлбөртэй холбоотойгоор гадаад валютын ханшийн эрсдэл үүсдэг. Компани нь гадаад валютын эрсдлийг гадаад валютын дериватив хэрэгслийг ашиглан хянадаггүй.

Компанийн гадаад валютаар үүссэн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг тайлангийн өдрийн байдлаар төгрөгөөр үзүүлбэл дараах байдалтай байна:

	2023		2022	
	Хөрөнгө	Өр төлбөр	Хөрөнгө	Өр төлбөр
Гадаад валютаар илэрхийлэгдсэн	61,366	1,284	16,632	427,505

Компанийн гадаад валютын ажил гүйлгээ нь ихэнхдээ америк доллар, юань болон рубль (хамтад нь "Гадаад валют" гэх)-р хийгддэг. Дээрх гадаад валютуудтай харьцах Монгол төгрөгийн ханш 10 хувиар өсөх/буурах үеийн мэдрэмжийг доорхи хүснэгтэнд харуулав. Гүйцэтгэх удирдлагын түвшинд гадаад валютын эрсдлийг үнэлэхдээ дээрх 10 хувийн мэдрэмжийг ашигладаг ба энэ нь гадаад валютын ханш дахь удирдлагын үнэлж буй боломжит өөрчлөлтийг илэрхийлнэ.

Энэхүү мэдрэмжийн шинжилгээ нь зөвхөн гадаад валютаар илэрхийлэгдсэн төлөгдөөгүй байгаа мөнгө болж хөрвөх санхүүгийн үзүүлэлтүүд болон тайлант хугацааны эцэс дэх гадаад валютын ханшийн 10 хувийн өөрчлөлтийн нөлөөллийг агуулдаг.

Хэрэв санхүүгийн тайлангийн өдрөөр төгрөгийн ханш дээрх гадаад валютуудын эсрэг 10%-иар чангарахад Компанийн татварын өмнөх ашиг дор хүснэгтэнд үзүүлснээр өснө. Энэхүү шинжилгээнд бусад бүх хувьсах үзүүлэлтүүдийг тогтмол гэж үзсэн.

	2023	2022
Татварын өмнөх ашигт үзүүлэх нөлөөлөл	(6,008)	41,087

Санхүүгийн тайлангийн өдрөөр бусад бүх үзүүлэлтүүд тогтмол байх үед төгрөгийн ханш бусад валютын эсрэг 10%-иар сулрахад Компанийн татварын өмнөх ашигт үзүүлэх нөлөөлөл дээрх дүнтэй тэнцүү боловч эсрэг нөлөө үзүүлнэ.

**ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД  
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2023 ОН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

**23. Санхүүгийн хэрэгсэл ба санхүүгийн эрсдлийн удирдлага (үргэлжлэл)**

**23.4 Санхүүгийн хэрэгсэлийн бодит үнэ цэнэ**

Компани нь үнэлгээний техникүүдийг ашиглан санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах шатлалуудыг хэрэглэдэг. Үүнд:

Зэрэглэл 1: Бодит үнэ цэнэ нь ижил төстэй санхүүгийн хэрэгслийн идэвхтэй зах зээл дээр тогтоосон үнэд үндэслэсэн байх;

Зэрэглэл 2: Бодит үнэ цэнийг хэмжихдээ ашигласан мэдээ нь зах зээл дээрээс шууд ба шууд бусаар олж авах боломжтой бусад техникүүд;

Зэрэглэл 3: Зах зээлийн мэдээлэлд үндэслэгдээгүй мэдээ ашиглан бодит үнэ цэнийг тооцоолох арга ашиглан тооцоолсон техникүүд.

Бодит үнэ цэнээрээ тусгагдаагүй санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийг Компани дараах байдлаар тодорхойлдог:

- (i) Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэй ойролцоо байгаа санхүүгийн хөрөнгө, өр төлбөр Түргэн хөрвөх чадвартай эсвэл нэг жилээс бага хугацаатай богино хугацааны санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд дансны үнэ нь тэдгээрийн бодит үнэ цэнтэй ойролцоо байна.
- (ii) Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэгсэл  
Тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг хорогдуулсан өртгөөр тооцож, анх хүлээн зөвшөөрөгдсөн үеийн зах зээлийн хүүг Монгол Улсад байгаа ижил төрлийн санхүүгийн хэрэгслүүдэд санал болгож буй зах зээлийн хүүтэй харьцуулах замаар тооцдог.

Компанийн санхүүгийн хэрэгсэл нь хорогдуулсан өртгөөр бүртгэсэн бусад санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрөөс бүрдэнэ. Удирдлага нь санхүүгийн тайланд тусгасан санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэ нь тэдгээрийн бодит үнэ цэнэтэй ойролцоо байна гэж үзэж байна.

**24. Капиталын эрсдэлийн удирдлага**

Компани тасралтгүй үйл ажиллагаа явуулах зорилгоор өөрийн капиталыг удирдахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчийн өгөөжийг хамгийн ихээр байлгахын тулд зээл болон өөрийн хөрөнгийн харьцааг оновчтой байлгахыг зорьдог. Компанийн үндсэн стратегийн бодлого 2022 оныхоос өөрчлөгдөөгүй байна.

**25. Тайлангийн дараах үйл явдал**

Компани нь 2024 оны 1-р сарын 31-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор нэгж хувьцаанд 4.68 төгрөгийн, нийт 5,607,170 мянган төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн.

Үүнээс өөр санхүүгийн тайланд нөлөөлөхүйц, тодруулахыг шаарддаг тайлангийн дараах үйл явдал гараагүй.

**26. Зэрэгцүүлэгдэх мэдээлэл**

Тайлант жилийн санхүүгийн үзүүлэлтүүдтэй зэрэгцүүлэх зорилгоор өмнөх жилийн зарим санхүүгийн үзүүлэлтүүдийг дахин ангилсан.